



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 5/05

Улаанбаатар хот

**Төрийн жинхэнэ албаны нөөцөд
бүртгэх тухай**

Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.8, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7, 3 дугаар зүйлийн 3.8, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1.Цагдаагийн байгууллагын захиалгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Чангшин их сургуулийг “Цагдаагийн удирдлага” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн Ганбаатарын Даваасүрэн, Алтансүхийн Мөнх-Эрдэнэ, Батбилэгийн Жаргалсайхан нарыг “Төрийн жинхэнэ албаны нөөц”-д бүртгэсүгэй.
2. Нөөцөд бүртгэгдсэн иргэдийг Цагдаагийн байгууллагын албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу томилохыг Хүний нөөцийн хэлтсийн дарга /цагдаагийн хурандаа Д.Батчулуун/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Х.Тулга/-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД